



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/35

Модот

**Газар эзэмшүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дүгээр зүйлийн 33.1.1 дахь заалтууд, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 24 дугаар тогтоолын 5 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлэхээр тусгагдсан Цэнхэрмандал сум, 4-р баг Баянмод, Модот хаягт байрлах, 4831604 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай, Цаг уурын харуулын ажиглалтын талбай, 2110 квадрат метр газрыг Хэнтий аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газарт (4185471)-т 30 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2.Холбогдох хууль тогтоомжид заасны хүрээнд газар эзэмших эрхээ хэрэгжүүлж, эзэмшиж авсан газраа хуулийн дагуу кадастрын болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3.Газар эзэмшигчид газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэх, газрын ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Я.Отгонтуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А. МӨНХ- ОРГИЛ